



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1990 оны 5

сарын 09 өдөр

Улаанбаатар

дугаар 81

№38-тн 1993 онд А/262д Зөвлөмжөөс хураагдсан

Улаанбаатар хотод үйлчилгээний лавлах алба байгуулах тухай.

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь: 1. Нийслэл хот өргөжин, хүн ам өсөж зорчигчид олширч байгаагаар холбогдуулан хөдөлмөрчдийн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор хотын шинжлэх ухаан, техникийн дэвшил, шинэ бүтээл оновчтой саналыг нэвтрүүлэхэд туслах товчооны дэргэд үйлчилгээний лавлах алба байгуулан ажиллуулахыг тус товчоо/н.Ганзориг/-нд зөвшөөрсүгэй.

2. Үйлчилгээний лавлах цэгүүд, мэдээлэл, зарлалын самбарыг бий болгоход шаардагдах 50,0 мянган төгрөгийг хотын төсвийн орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсний шагналын хөрөнгөөс гаргахыг санхүүгийн хэлтэс/н.Гонгор/-т даалгасугай.

3. Үйлчилгээний лавлах албыг ажиллуулахад шаардлагатай мэдээлэл, лавлагааны бичиг, баримтыг дээрх товчооны захиалгаар тухай бүрд нь гарган өгч байхыг хотын нийт байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4. Үйлчилгээний лавлах гурван цэгт телефон, таксофон тавьж өгөхийг Телефон радио ашиглалтын хороо /н.Банзрагч/-нд даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

*[Signature]* Л.ЭНЭБИШ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧИЙН ДАРГА

*[Signature]* Д.АЛША